



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/331

Хэрлэн сум

Халдваргүйтгэлийн түр хяналтын
цэг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дүгээр зүйлийн 28.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолын “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах тухай” нэгдүгээр хавсралт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, Аймгийн онцгой комиссын 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах өвчин, бог малын мялзан, хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 06 дугаар сарын 24-өөс 30 хоногийн хугацаанд Хэрлэн сумын гүүрний урд Петровис шатахуун түгээх станцын орчимд, Баян-Овоо сумын гүүрэн дээр халдваргүйтгэл хяналтын цэг ажиллуулахад зориулж 4,480,800 (дөрвөн сая дөрвөн зуун наян мянга найман зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Халдваргүйтгэл хяналтын цэг ажиллуулахад шаардагдах зардлын тооцоо нэгдүгээр хавсралтаар, тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлд тээврийн хэрэгслийг бүрэн хамруулж, шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, халдвар хамгааллын хувцас, хэрэглэл, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр), Баян-Овоо сумын Засаг дарга (Д.Баянмөнх), Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч (М.Шүрэнцэцэг) нарт тус тус даалгасугай.

Аймгийн Засаг даргын 2022 оны
... дугаар сарын ... ны дугаар
... захирамжийн хавсралт

Баян-Овоо, Хэрлэн сумын түр алдваргүйтгэл,
хяналтын цэгийн шаардагдах зардлын нийт тооцоо

| Д/д | Зардлын нэр | Нэгжийн үнэ | Тоо хэмжээ | Нийт зардал |
|-----|-------------------------|-------------|-----------------|-------------|
| 1 | Хоол хүнсний зардал | 24000 | 30 хоног/ 6 хүн | 4320000 |
| 2 | Шатахууны зардал | 2520 | 40 литр | 100800 |
| 3 | Телефон холбооны зардал | 10000 | 6 хүн | 60000 |
| | | | | 4480800 |

Баян-овоо, хэрлэн сумын гүүрэнд түр халдваргүйтгэлийн
цэгт үүрэг гүйцэтгэх албан хаагчдын хуваарь

| Д/д | Байгууллага | Албан хаагчдын тоо | Ажиллах хоног |
|-----|---------------------------------|--------------------|---------------|
| 1 | Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж | 2 | 30 |
| 2 | Цагдаагийн газар | 2 | 30 |
| 3 | Сумын Засаг даргын тамгын газар | 2 | 30 |

Аймгийн Засаг даргын 2022 оны
06 дугаар сарын 23-ны

АХС/ дугаар захирамжийн хавсралт



Тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэх үйлчилгээний хураамж

| № | Тээврийн хэрэгслийн төрөл | Тээврийн хэрэслийн даац /тн/ | Хураам /төг/ |
|---|---|------------------------------|--------------|
| 1 | Суудлын машин | 0.5 тонноос доош | 1000 |
| 2 | Ачааны машин /портер, маяги түүнтэй адилтгах/ | 1.5 тонн | 2000 |
| 3 | Ачааны машин | 5 тонноос дээш | 5000 |